



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/20

Эрдэнэт

“Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга фермер”,
“Аймгийн аварга тариаланч” шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/729 дүгээр “Аймгийн аварга малчин, фермер, тариаланч, тариаланч хамт олон шалгаруулах журам батлах тухай” захирамж, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны II хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. XVII жарны Төмөр үхэр жилийн сар шинийн баярыг тохиолдуулан мал аж ахуйн салбарт үр бүтээлтэй ажиллаж, мал сүргээ төрөл бүр дээр нь өсгөн, малынхаа үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулж, шинээр ажлын байр бий болгож малгүй өрхүүдийг малжуулан, орон нутгийн зах зээлд мах, сүү, ноос, ноолуур, арьс ширний борлуулалт хийж, хүн амын хүнсний хангамж, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан Баян-Өндөр сумын Малчин багийн малчин Галсангийн Сундуйжав, Жаргалант сумын Дулаан-Уул багийн малчин Жигмэдийн Төмөрпүрэв нарыг “Аймгийн аварга малчин”-аар, Баян-Өндөр сумын Говил багийн фермер Жамъяансүрэнгийн Ганзоригийг “Аймгийн аварга фермер”-ээр, Газар тариалангийн салбарт үр бүтээлтэй ажиллаж, тариалалт, талбайн хөрс боловсруулалт, ургамал хамгааллын ажлыг технологийн дагуу чанартай сайн гүйцэтгэн, хөрсний үржил шимийг нэмэгдүүлж, арвин ургац хураан авч орон нутгийн зах зээлд борлуулан, ажлын байрыг нэмэгдүүлж, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан Жаргалант сумын Улаантолгой багийн тариаланч Дүгэрсүрэнгийн Бямбажав, Жаргалант сумын Улаантолгой багийн тариаланч Батчулууны Жавхлан, Баян-Өндөр сумын Даваат багийн тариаланч Хашбаатарын Хосбаяр, Баян-Өндөр сумын Дэнж багийн тариаланч Халтарын Баттөр нарыг “Аймгийн аварга тариаланч”-аар шалгаруулж өргөмжлөл, энгэрийн тэмдэг, мөнгөн шагналаар шагнасугай.

2. Шагналд шаардагдах зардлыг I, шагнал гардуулах ажлаар малчны хот руу явахад шаардагдах шатахууны зардлыг II хавсралтаар баталсугай.

3. Шагналд шаардагдах 8,273,000 (найман сая хоёр зуун далан гурван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Бямбацэцэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ

